

хумуус энэхуу Гэрээний заалтын дагуу өргөдлөө гарган Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний харьяатыг сонгож авна.

2. Харьяатаа сонгон авах тухай хоёр эх хувь өргөдлийг энэхуу Гэрээг хучин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор гарган харьяатыг нь сонгон авах Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН эрх бүхий байгууллагад өгнө.

3. Энэхуу зүйлийн I-д заасан хумуус нь харьяатаа сонгон авах тухай өргөдлийг:

а) хэрэв тэд, нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН харьяатыг сонгон авах бол тууний эрх бүхий байгууллагад;

б) хэрэв тэд, Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний нутаг дэвсгэрт оршин суугаа бөгөөд Хэлэлцэн Тохирогч нөгөө ЭТГЭЭДИЙН харьяатыг сонгон авах бол Хэлэлцэн Тохирогч нөгөө ЭТГЭЭДИЙН дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт;

в) хэрэв тэд гуравдахь улсын нутаг дэвсгэрт оршин суугаа бол харьяатыг сонгон авах Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт тус тус гаргана.

4. Харьяатыг нь сонгон авах Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН үндэний хууль тогтоомжийн дагуу тэд өргөдлөө гаргана.

Хоёрдугаар зүйл

Зөвхөн насанд хурэгсэд харьяатыг сонгон авах тухай өргөдөл гаргах эрхтэй байна. Насанд хурэгсэд гэж 18 нас хүрэн хумуусийг хэлэх бөгөөд туунчлэн Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний үндэний хууль тогтоомжийн дагуу насанд хурэгсдийн эрх эдлэх хумуусийг хэлнэ.

Гуравдугаар зүйл

1. Энэхуу Гэрээний нэгдүгээр зүйлийн дагуу харьяатаа сонгон авах тухай өргөдөл гаргаагүй хумуус өргөдөл өгөх хугацаа дууссан өдрөөс эхлэн, нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

2. Энэхуу Гэрээний нэгдүгээр зүйлийн дагуу харьяатаа сонгон авах тухай өргөдөл гаргаагүй бөгөөд гуравдахь улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хумуус эл улсад ирэхээс өмнө нутаг дэвсгэрт нь оршин сууж байсан Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

Дөрөвдүгээр зүйл

Энэхуу Гэрээг хучин төгөлдөр болохоос өмнө төрсөн бөгөөд Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль алины нь харьяат байгаа насанд хурээгүй хуухдийн эцэг, эх нь Гэрээ хучин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор энэхуу Гэрээний нэгдүгээр зүйлийн 3-т дурдсан байгууллагад ижил хоёр хувь үйлдсэн өргөдлийг гаргаж, туунд Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний харьяатыг сонгон авна. Харьяатыг сонгон авах тухай өргөдөл гаргахдаа эцэг, эх нь насанд хурээгүй хуухдийн саналыг авах бөгөөд энэ нь харьяатыг нь сонгон авч байгаа Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.

Тавдугаар зүйл

1. Энэхуу Гэрээний дөрөвдүгээр зүйлийн дагуу, харьяатыг нь сонгон авах тухай эцэг, эх нь өргөдөл гаргаагүй насанд хурээгүй хуухэд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг дөрөвдүгээр зүйлд заасан хугацаа дууссан өдрөөс эхлэн хадгална.

2. Гуравдахь улсын нутаг дэвсгэрт оршин суугаа насанд хурээгүй хуухдийн эцэг, эх нь Энэхуу Гэрээний дөрөвдү-

гээр зүйлийн дагуу хуухдийнхээ харьяатыг сонгон авах талаар харилцан тохиролцоогүй бол эцэг, эх нь гуравдахь улсад явахын өмнө нутаг дэвсгэрт нь оршин сууж байсан Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална. Хэрэв эцэг, эх нь Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний нутаг дэвсгэрт хамт амьдран сууж байгаагүй бол хуухэд нь эхийнхээ харьяат байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

3. Эцэг, эх нь гэр бул болоогүй бөгөөд дөрөвдүгээр зүйлийн дагуу харьяатыг нь сонгон авах талаар эцэг, эх нь өргөдөл гаргаагүй насанд хурээгүй хуухэд, туунийг асран хумуужуулэх уурэг хүлээсэн эцэг буюу эхийн харьяат байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

4. Эцэг, эх нь нас барсан буюу хаана байгаа нь мэдэгдэхгүй, эсгул эцэг, эх байх эрхээ хасуулсан бол тэдний насанд хурээгүй хуухэд дөрөвдүгээр зүйлд заасан хугацаа дууссан өдрөөс эхлэн, нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

5. Хэрэв дөрөвдүгээр зүйлд заасан хугацаа дуусахаас өмнө эцэг, эхийн аль нэг нь нас барсан буюу хаана байгаа нь мэдэгдэхгүй, эсгул эцэг буюу эх байх эрхээ хасуулсан бол тэдний насанд хурээгүй хуухэд аль байгаа эцэг буюу эхийн харьяат байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

Зургадугаар зүйл

Хэрэв харьяат сонгон авах тухай өргөдөл өгсөн хумуус буюу өргөдөл нь өгөгдсөн насанд хурээгүй хуухдийн өргөдлийг хүлээн авсан хэлэлцэн тохирогч этгээд уул иргэн харьяат нь биш байж өргөдөл гаргалаа гэж мэдвэл тэрхуу өргөдлийг хууль ёсны хучинтэй гэж үзэхгүй.

И БУЛЭГ

ХОЁРДМОЛ ХАРЬАЛАЛ ҮҮСЭХ ЯВДЛЫГ ГАРГУУЛАХГУЙ БАЙХ ТУХАЙ

Долдугаар зүйл

1. Эцэг, эхийн аль нэг нь Хэлэлцэн Тохирогч нэгэн ЭТГЭЭДИЙН харьяат, нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө ЭТГЭЭДИЙН харьяат байгаа бол тэд Энэхуу Гэрээг хучин төгөлдөр болсноос хойш төрсөн хуухэддээ Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний харьяатыг сонгон авч болно.

2. Хуухдээ төрснөөс хойш 6 сарын дотор эцэг, эх нь тууний харьяатыг сонгон авах тухай санал нэгтэй өргөдлийг хоёр ижил хувь үйлдэж харьяатыг нь сонгон авч байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН эрх бүхий байгууллагад өгч хуухэддээ харьяатыг сонгож авна.

Наймдугаар зүйл

Энэхуу Гэрээний долдугаар зүйлийн дагуу харьяатыг сонгон авах тухай гаргасан өргөдлийг:

а) хэрэв нутаг дэвсгэрт нь эцэг, эх нь оршин сууж байгаа Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН харьяатыг сонгон авч байгаа бол тэдний оршин суугаа газрын эрх бүхий байгууллагууд;

б) хэрэв эцэг, эх нь Хэлэлцэн Тохирогч нөгөө ЭТГЭЭДИЙН буюу гуравдахь улсын нутаг дэвсгэрт оршин суугаа бол харьяатыг нь сонгон авч байгаа Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН дипломат төлөөлөгчийн буюу консулын газрууд;

в) хэрэв эцэг эхийн аль нэг нь Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний нутаг дэвсгэрт, нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө ЭТГЭЭДИЙН нутаг дэвсгэрт оршин суугаа бол эхийнх нь оршин суугаа газрын эрх бүхий байгууллага тус тус хүлээн авна.